



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/304

Алтай хот

Салбар комисс шинэчлэн байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 173 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ийн 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн (0-16 нас) эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах хэрэгжилтэд хяналт тавих комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Комиссын дарга: -(Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
- Гишүүд: -(Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн их эмч)
-(Нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн их эмч)
-(Боловсрол, шинжлэх ухааны газрын тусгай хэрэгцээт боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн)
-(Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
-(Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөлөл)
- Нарийн бичгийн дарга:-(Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын хөгжлийн бэрхшээлтэй иргэд хариуцсан мэргэжилтэн)

2.

2.Салбар комиссын үйл ажиллагааг тогтмолжуулж , хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг нөхөн олгох, эрүүл мэндийн сэргээн засал, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин, ажлын үр дүнг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг комисс (С.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

3.Захирамж гарсантай холбогдуулан 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/87 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР